

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын дэргэд үйл ажиллагаа явуулах Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг дээшлүүлэх зорилго бүхий "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв" тун удахгүй нээгдэхээр ажиллаж байна. Тус аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн нэгж хамтран байгуулж буй энэхүү төв Хөдөлмөрийн зах зээлд хөл тавьж байгаа залуучууд, ялангуяа сургууль төгссөн, ажлын бага туршлагатай залуучуудыг ажлын байранд зуучлах зорилготой юм. Тус загвар төв нь ажил хайгч бүрийн онцлогт тохируулан хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө гаргах, тэднийг бүлгийн сургалт болон бусад үйл ажиллагаанд хамруулах замаар хөдөлмөр эрхлэх чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулах юм.

Мөн сумуудад дотоод хяналт, шалгалт хийж байна.